

АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“МӨНХДААТГАЛ” ХХК-ИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: 2023/49/СТА/

Хаяг: УБ хот, БГДүүрэг, 8-р хороо,
Чингүнжавын гудамж, К4 апартмент
76 тоот

Цахим хаяг: accounttrust@yahoo.com
acctrust.audit@gmail.com

Улаанбаатар хот
2023 он

Гүйцэтгэх захирал: П.Наранцэцэг

Аудитор: Ч.Замбага

Утас: 7011-7889, 9913-0778

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Агуулга

1. ДҮГНЭЛТ.....	2
2. АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД.....	9



АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК

УБ хот, БГДүүрэг, 8-р хороо, Чингүнжавын
гудамж, K4 апартмент 76 тоот
Утас : 7011-7889, 9913-078
E-mail : acctrust.audit@gmail.com

“МӨНХДААТГАЛ” ХХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн Тайлангийн талаарх Аудитын Тайлан Дүгнэлт

Бид “Мөнхдаатгал” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь “Мөнхдаатгал” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (цаашид “СТОУС” гэх) -ын дагуу үнэн зөв илэрхийлж байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Үүрэг Хариуцлага хэсэгт тусгасан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байж, аудиторын ёс зүйн бусад үүрэг хариуцлагыг мөрдөж ажилласан. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг СТОУС-уудын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаагүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааны тасралтгүй явуулах чадамжийн талаар тодруулах, мөн компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий

аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болж, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмжээ ашиглан мэргэжлийн үл итгэх зарчмыг баримталсан болно. Мөн түүнчлэн бид:

- Залилан болон алдаанаас үүсч болохуйц санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлон үнэлж, уг эрсдлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс өндөр байдаг. Учир нь залилангийн үед хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл хэрэгжүүлэх явдлууд тохиолдсон байж болдог.

- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтыг судалдаг ба энэ нь Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгуудын бодитой байдлыг үнэлдэг.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа болон санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах ба ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчилдөг. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэсэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид бусад асуудлуудын дундаас аудитыг ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

П.Наранцэцэг
Гүйцэтгэх захирал, МНБ
Монгол улс, Улаанбаатар хот
2023 оны 3-р сарын 27-ны өдөр



2. АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД РУУ ЛГА	/төгрөгөөр/	
		2021.12.31	2022.12.31
ХӨРӨНГӨ			
<u>Эргэлтийн хөрөнгө</u>			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1	246,881,713.11	244,287,942.99
Касс	1	27,366,010.00	26,161,219.12
Харилцах	1	219,515,703.11	218,126,723.87
Дансны авлага	2	699,479,365.76	1,235,712,405.50
Даатгалын хураамж авлага	2	382,800,983.71	1,109,639,328.49
Давхар даатгалын авлага	2	316,678,382.05	126,073,077.01
Татвар, НДШ-ийн авлага	3	41,692,882.66	425,240.17
Бусад авлага	4	178,942,392.34	863,142,444.01
Бараа материал	5	120,327,539.00	88,318,824.00
Урьдчилж төлсөн зардал тооцоо	6	56,591,000.00	-
давхар даатгалын Хойшлогдсон хураамж	7	75,748,767.67	718,206,226.49
<u>Эргэлтийн хөрөнгийн дүн</u>		<u>1,419,663,660.54</u>	<u>3,150,093,083.16</u>
<u>Эргэлтийн бус хөрөнгө</u>			
Үндсэн хөрөнгө	8	2,902,615,304.57	3,320,566,986.84
Урт хугацаат хөрөнгө оруулалт	9	5,417,567,278.07	5,754,172,433.91
Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	8	650,927,500.00	690,000,000.00
Хөрөнгийн биржийн үнэт цаас	9	113,000,000.00	233,000,000.00
<u>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</u>		<u>9,084,110,082.64</u>	<u>9,997,739,420.75</u>
<u>НИЙТ ХӨРӨНГӨ</u>		<u>10,503,773,743.18</u>	<u>13,147,832,503.91</u>
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
<u>Богино хугацаат өр төлбөр</u>			
Дансны өглөг	12	33,054,946.67	180,709,287.23
Цалингийн өглөг	12	239,640.00	-
Татварын өр	13	48,802,936.13	68,924,566.56
НДШ-ийн өглөг	13	11,924,900.66	-
Урьдчилж орсон орлого	12	-	100,084,210.00
<u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u>		<u>94,022,423.46</u>	<u>349,718,063.79</u>
<u>Урт хугацаат өр төлбөр</u>			
Нөөц / өр төлбөр/	14	3,925,127,781.75	5,795,404,203.10
<u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u>		<u>3,925,127,781.75</u>	<u>5,795,404,203.10</u>
<u>Өр төлбөрийн нийт дүн</u>		<u>4,019,150,205.21</u>	<u>6,145,122,266.89</u>
Эздийн өмч			
Хувийн өмч		5,000,000,000.00	5,000,000,000.00
Хуримтлагдсан ашиг		1,484,623,537.97	2,002,710,237.02
<u>Эздийн өмчийн дүн</u>		<u>6,484,623,537.97</u>	<u>7,002,710,237.02</u>
<u>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</u>		<u>10,503,773,743.18</u>	<u>13,147,832,503.91</u>

Тайлангууд нь энэхүү дүгнэлтийн салшгүй хэсэг болно.

2.2 Аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлт	2021.12.31	/ төгрөгөөр/ 2022.12.31
Даатгалын үйл ажиллагаа	7,183,509,956.84	12,026,186,365.06
Нийт хураамжийн орлого	7,183,509,956.84	12,026,186,365.06
Даатгалын хураамж буцаалт /-/	249,458,847.00	377,015,649.91
Давхар даатгалын хураамжийн зардал	982,329,277.84	780,195,096.37
Даатгалын хураамж цэвэр орлого	5,951,721,832.00	10,868,975,618.78
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт нийт дүнгээр /+/-/	865,375,941.81	1,429,459,977.14
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ноогдох хэсгийн өөрчлөлт /+/-/	(10,760,912.33)	642,457,458.82
Орлогод тооцсон хураамжийн цэвэр орлого	5,075,584,977.86	10,081,973,100.46
Нийт нөхөн төлбөр	2,031,165,348.99	3,801,445,857.51
Давхар даатгалын хариуцах нөхөн төлбөр	425,659,222.56	108,488,866.91
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	161,730,641.20	717,732.27
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	(106,274,626.26)	440,098,711.94
Зардалд тооцсон нөхөн төлбөр	1,660,962,141.37	4,133,773,434.81
Даатгалын гэрээний цэвэр зардал		1,738,051,139.83
Даатгалын үйл ажиллагааны ашиг алдагдал	3,414,622,836.48	4,210,148,525.82
Бусад орлого	421,316,423.04	504,428,606.48
Ерөнхий ба удирдлагын зардал	3,370,160,514.00	4,152,554,756.77
Бусад зардал	-	13,772,728.27
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	27,402,240.57
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	465,778,745.52	575,651,887.83
Орлогын татварын зардал	46,577,874.55	57,565,188.78
Татварын дараах ашиг (алдагдал)	419,200,870.97	518,086,699.05
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	419,200,870.97	518,086,699.05
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Орлогын нийт дүн	419,200,870.97	518,086,699.05

Тайлангууд нь энэхүү дүгнэлтийн салшгүй хэсэг болно.

2.3 Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<u>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</u>	5,000,000,000.00	1,065,422,667.00	6,065,422,667.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
<u>Залруулсан үлдэгдэл</u>	5,000,000,000.00	1,065,422,667.00	6,065,422,667.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	419,200,870.97	419,200,870.97
<u>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</u>	5,000,000,000.00	1,484,623,537.97	6,484,623,537.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
<u>Залруулсан үлдэгдэл</u>	5,000,000,000.00	1,484,623,537.97	6,484,623,537.97
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	518,086,699.05	518,086,699.05
<u>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</u>	5,000,000,000.00	2,002,710,237.02	7,002,710,237.02

Тайлангууд нь энэхүү дүгнэлтийн салшгүй хэсэг болно.

2.4 Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан

		/ төгрөгөөр/	
Үзүүлэлт		2021.12.31	2022.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>		<u>7,183,509,956.84</u>	<u>12,026,186,365.06</u>
Даатгалын хураамийн орлого		7,183,509,956.84	12,026,186,365.06
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>		<u>6,196,502,974.76</u>	<u>10,958,789,447.03</u>
Ажиллагчдад төлсөн		516,656,065.07	824,316,317.47
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн/хөнгөлөлт +/		130,674,960.42	205,158,804.94
Бараа материал худалдан авахад төлсөн		287,210,378.50	617,520,195.53
Ашиглалтын зардалд төлсөн		910,800,947.00	2,364,062,699.64
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж		982,329,277.84	780,195,096.49
Нөхөн төлбөрт төлсөн		2,031,165,348.99	3,801,445,857.51
Үүнээс: Сайн дурын даатгалын		-	2,719,717,024.51
Албан журмын даатгалын		-	1,081,728,833.00
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл		354,406,240.57	816,742,158.06
Даатгалын зуучид төлсөн төлбөр		407,790,507.46	921,308,981.77
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		194,066,321.51	152,491,853.60
Хүүний төлбөрт төлсөн		-	41,385,190.24
Татварын байгууллагад төлсөн		131,944,080.40	57,146,641.87
Даатгалын хураамж буцаалт		249,458,847.00	377,015,649.91
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		<u>987,006,982.07</u>	<u>1,067,396,918.03</u>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>		<u>421,316,423.04</u>	<u>504,428,606.48</u>
Хөрөнгө оруулалтын орлого		421,316,423.04	504,428,606.48
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>		<u>1,750,927,500.00</u>	<u>1,601,821,535.20</u>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1,100,000,000.00	650,927,500.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		650,927,500.00	950,894,035.20
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		<u>(1,329,611,076.96)</u>	<u>(1,097,392,928.72)</u>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>		<u>-</u>	<u>-</u>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-	-
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>		<u>-</u>	<u>-</u>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		<u>-</u>	<u>-</u>
Валютын ханшийн зөрүү		-	27,402,240.57
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		<u>(342,604,094.89)</u>	<u>(2,593,770.12)</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		<u>589,485,808.00</u>	<u>246,881,713.11</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		<u>246,881,713.11</u>	<u>244,287,942.99</u>

Тайлангууд нь энэхүү дүгнэлтийн салшгүй хэсэг болно.